

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ДЦС-4” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ТӨМӨРХУЯГ

“ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-4” ТӨХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2688352)

БОЛОВСРУУЛСАН:

“ДЦС-4” ТӨХК-ИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДАРГА



Ж.ЭНХЦОГТ

2025 ОН

Агуулга

1. Станцын товч танилцуулга
2. Станцын талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт
3. Станцын гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
4. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

1. “ДЦС-4” ТӨХК-ийн товч танилцуулга

Улсын бүртгэлийн гэрчилгээ Регистрийн дугаар	9012001018 2688352
Хаяг	16101 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж Утас: 70171284; Имэйл: info@tpp4.mn
Газар эзэмших эрхийн гэрчилгээ	Дугаар: 0000047361 Дугаар: 0000010665



Зураг 1. “ДЦС-4” ТӨХК-ийн байршил

Түүхэн товчоон

“ДЦС-4” ТӨХК-ийн суурийг 1979 онд тавьж, 1983 онд эхний агрегат, 1987 онд төслийн буюу 380 МВт-ын хүчин чадлаар ашиглалтанд орж улмаар 1988-1990 онуудад 160 МВт-ын, 2007, 2009 онд 2х20 МВт, 2012-2014 онд 120 МВт, 2018-2021 онд 89 МВт-ын өргөтгөл хийгдэн нийт 772 МВт-ын цахилгаан эрчим хүчний, 1586 Гкал дулааны эрчим хүчний суурилагдсан хүчин чадалтай ажиллаж байна.

Төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 60 орчим хувийг, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний 55 орчим хувийг хангаж байна.

Суурилагдсан тоноглолын техникийн үзүүлэлт

- **Станцын төрөл, ангилал:** хөндлөн холбоос бүхий 8 зуух, 7 турбинтэй цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх схемтэй;
- **Уурын генератор:** 13,8 МПа (140 кгс/см²) даралттай 560⁰С температуртай хэт халуун уурыг цагт 500 тонныг үйлдвэрлэх хүчин чадалтай БКЗ-420-140-10С (ОХУ) маркийн 8 зуух;
- **Уурын турбин:** цагт 123 МВт цахилгаан эрчим хүч, 187 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай Т-123/130-12,8 ПРЗ-1 (ОХУ) маркийн зөвхөн дулаацуулгын (отбор) авлагатай 3 турбин;
цагт 80 МВт цахилгаан эрчим хүч, 220 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай ПТ-80/100-130/13 (ОХУ) маркийн үйлдвэрийн болон дулаацуулгын (отбор) авлагатай 2 турбин;
цагт 100 МВт цахилгаан эрчим хүч, 103 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай ПТ-100/110-128,8-1,3 (ОХУ) маркийн үйлдвэрийн болон дулаацуулгын (отбор) авлагатай 1 турбин;
цагт 120 МВт цахилгаан эрчим хүч, 188 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай Т-120/130-130-8МО (ОХУ) маркийн үйлдвэрийн болон дулаацуулгын (отбор) авлагатай 1 турбин.
- **Турбогенераторын эргэлт:** 3000 эрг/мин; цахилгаан генераторын хүчдэл: 10,5кВ; блок трансформаторын хүчдэл-110, 220кВ.
- **Үндсэн түлш:** Б2 маркийн Багануур, Шивээ-Овоогийн хүрэн нүүрс;
- **Галлагааны түлш:** М-100 маркийн мазут;
- **Түлш тээвэрлэлт:** төмөр зам;
- **Нүүрс буулгах систем:** 125 тн хүртэл даацтай 1 полувагоныг 5 минутанд хөмрөх хүчин чадалтай ВРС-125 маркийн 2 ш вагон хөмрөгч;
- **Түлш, тос хадгалах нөөц:** 240000 тн нүүрс нөөцлөх ил талбай, 5000 м³ мазут хадгалах 4 ш сав, 700 м³ тос хадгалах сав;
- **Үнс зайлуулах систем:** нойтон, усаа буцааж олон дахин ашигладаг, 3 км алслагдсан үнсэн сантай;
- **Утааны хийг цэвэрлэх төхөөрөмж:** ЭГА-2-58-12-6-4 маркийн цахилгаан шүүлтүүр, бүтээмж 97-98%;
- **Ус цэвэрлэх систем:** дэвшилтэт мембран технологи бүхий бүрэн автомат ажиллагаатай станцын дотоод циклийн нэмэлт ус бэлтгэлийн 250 м³/ц-ийн хүчин чадалтай төхөөрөмж;
- **Ус хангамж:** 20 км-т алслагдсан техникийн ус хангамжийн аж ахуй, бүтээмж 1600 м³/ц
- **Утааны яндан:** өндөр 250 м, амсрын голч - 8 м, суурийн голч - 36 м.

Үйлдвэрлэл, технологийн 6 цех, механик боловсруулалтын 1 цех, үйлдвэрлэл, засвар, судалгаа хөгжлийн 3 алба, захиргаа хүний нөөц, хяналт, борлуулалт маркетингийн 3 алба, төлөвлөлт эдийн засаг, санхүү бүртгэл, худалдан авах ажиллагаа, нийгэм ахуйн 4 хэлтэс, эмнэлэг, зоогийн газар, авто аж ахуй гэсэн нэгжийн зохион байгуулалттай үйл ажиллагааны холимог бүтэцтэй ажил үйлчилгээ явуулдаг.

2025 оны байдлаар нийт 1490 ажиллагсадтай байгаагаас 298 ажилтан нь инженер техникийн ажилтан байна.

2001 оны 8-р сараас Төрийн өмчийн Хувьцаат Компани болж, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 335 дугаар тогтоолоор эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж байна.

2. Станцын талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

ДЦС-4 ТӨХК нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хороонд өөрийн байранд байрлана. Тус станцын харъяанд 3-20 км алслагдсан үнс хадгалах сан, техникийн ус хангамжийн насос станц болон ахуй үйлчилгээний, инженерийн, лабораторийн зэрэг 74,2 га талбай бүхий 74 барилга байгууламж багтдаг.

Дулааны цахилгаан станц нь улс орны болон бүс нутгийн ашиг орлого, дэд бүтцийн хөгжлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Улсын төсөвт ашгийн татвар, хүн амын орлогын албан татвар, агаарын бохирдлын төлбөр, нийгмийн даатгалын шимтгэл, газар ашигласны төлбөр, ус ашигласны төлбөр ашиглахтай холбогдох татвар, төлбөрийг оруулдаг.



Зураг 2. Үнсэн сангийн байршил

3. Станцын гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

3.1. Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл

- Зуухны яндангаас ялгарч буй бохирдуулагч бодис
- Нүүрсний хадгалалт, буулгалтын үед нүүрсний жижиг хэсгүүд салхиар зөөгдөх
- Химийн бодисын ашиглалтын үед үүсэх хорт хий
- Үнсэн сан, үнс зайлуулах төхөөрөмж, зуухны орчимд ялгарч буй тоосжилт
- Дуу шуугиан, доргио чичиргээ

- Хөргөх цамхагаас үүсч буй усны уурын бохирдол

Нөлөөллийн эх үүсвэр

Дулааны цахилгаан станцын үйлдвэрлэлийн түүхий эд болох түүхий нүүрс, мазут болон үнсэн сан, ус бэлтгэлд ашигладаг химийн бодис орно.

3.2. Хөрс, газрын гадаргад үзүүлж болзошгүй нөлөөлөл

Барилга байгууламж, хаягдлын хуримтлал болон бусад холбогдох байгууламжийн үйл ажиллагааны улмаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох, хүн болон амьтдад аюултай нөхцөл, эрсдэл үүсгэх магадлалтай. Тоног төхөөрөмжийг шинэчлэн суурилуулах үйл ажиллагааны дараа бий болсон элэгдэл эвдрэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах, тэдгээрээс бий болж болзошгүй бохирдлоос хамгаалах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай. Мөн түүний эргэн тойрны тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэлттай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, талхлагдах, ургамлан нөмрөг усах, бүрхэц нь багасахын зэрэгцээ тоос, үйлдвэрийн болон ахуйн хатуу, шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдхүүнээр бохирдох нөлөөллүүд үүснэ.

Нөлөөллийн эх үүсвэр

Материал түүхий эд ачих, тээвэрлэх, үнсэн сан, химийн болон шатах тослох материалын агуулах, автомашины хөдөлгөөн, үйлдвэрийн технологийн болон ахуйн хаягдал, түүний байгууламж орно.

3.3. Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөлөл

Газар доорхи усан орчин бохирдсон тохиолдолд хөрсөөр дамжин хүрээгээ тэлж, хүн, мал, амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлнө. Төсөл хэрэгжсэнээр гадаргын болон газрын доорхи усны хэрэглээг нэмэгдүүлснээр усны нөөц хомсдох, химийн бодис, урвалж агуулах боломжтой бохир ус хөрсөнд алдагдвал усан орчин бохирдоно.

Нөлөөллийн эх үүсвэр

- Хаягдлын болон нүүрсний овоолго
- Нефтийн бүтээгдхүүний буруу хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой осол
- Үнсэн сангийн шүүрэлт, сэтрэлт
- Химийн урвалж, бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалын гарч болзошгүй осол
- Үйлдвэрийн хаягдал болон ахуйн бохир усны шугам сүлжээний гэмтэл
- Гадаргын ус цуглуулах байгууламжид гарах эвдрэл, гэмтэл

4. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилт

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа 2024 оны байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1. Агаарын чанар									
1	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Яндангийн утааны хийн CEMS хяналтын систем, автомат төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг тогтмол хянах	Цахилгаан станцын уурын зуух	-			Үйл ажиллагааны зардал	Өдөр бүр	“Агаарын тухай” МУ-ын хууль MNS 4585:2016 Агаарын чанар MNS 5885:2008 Агаар байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 4585:2016 MNS 5919:2008
2		Яндангаас гарах утааны хийд мониторинг хийх, нийт хэмжээг тооцоолох	Утааны хий	тн		12		Сар бүр	
3		Үнсэн сангийн үнсний хийсэлтийг багасгах арга хэмжээ авч ажиллах; Үнсэн сангийн гадаргыг байнгын устай байлгаж, хуурайшиж, үнс хийсэхээс сэргийлэх	Үнсэн сангийн талбай	м³	-	-	6,722,830	Жил бүр	
4		ТДЦ-ийн дотоод орчинд тоосжилт бууруулах арга хэмжээ авах; Тоосны хяналт шинжилгээг тогтмол хийх	Түлш дамжуулах цех	-	Дотоод хяналт			Жил бүр	
5		Түлш хадгалалтын талбайг салхинаас хамгаалах тор, хашаа байгуулах	Нүүрс хадгалах талбай	м			Үйл ажиллагааны зардал	2025-2026	

2. Дуу шуугиан									
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ нь орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ.	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр тогтмол хангах; Ажилтны ХАБ-ын шаардлагыг биелүүлж буй эсэхэд хяналт тавих	Ажилчид				Дотоод хяналт	Жил бүр	MN 6768:2019
2		Зуух, турбин цехийн дуу шуугианы хэмжилтийг тогтмол хийж, хяналт тавих	Зуух, турбин цех				Дотоод хяналт	Жил бүр	MN 6768:2019
3. Гадаргын болон газрын доорхи усны нөөц									
1	Төслийн усны хэрэгцээнээс гадаргын болон газар доорхи усны нөөцийн хомсдол үүсэх	Ус ашиглах гэрээ, дүгнэлт гаргуулах	-	-	-		Дотоод хяналт	Жил бүр	Усны тухай МУ-ын хууль 24.2; 31.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
2		Ус ашигласны төлбөрийг улирал бүр төлөх	-	-	-			Жил бүр	
3		Хаягдал усны дүгнэлт гаргуулж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	-	-	-			Жил бүр	
5	Усан орчин бохирдох	Үнсэн сангийн мониторингийн худгийн усны түвшин, усны чанарын болон горимын ажиглалтыг тогтмол явуулах	Техникийн усны худаг				Үйл ажиллагааны зардал	Сар тутам	“Усны тухай” МУ-ын хууль болон холбогдох дүрэм журам “MNS” 0900:2018 “MNS” 4943:2015
6		Техникийн усны ашиглалтын бүртгэл, мэдээллийг хадгалж архив үүсгэх	Техникийн усны худаг				Үйл ажиллагааны зардал	Улирал тутам	
7		Үнсэн сангийн хяналтын худгийн усны түвшин, усны чанар болон горимын ажиглалтыг тогтмол явуулах	Үнсэн сангийн талбай				Үйл ажиллагааны зардал	Улирал тутам	

4. Хөрсөн бүрхэвч									
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Хөрс сийрэгжих, үржил шим алдагдаж, доройтох	Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хөрсний эвдрэл, доройтлыг бууруулах, нөхөн сэргээх	Станцын эзэмшлийн талбайд	м²			Үйл ажил-лагааны зардал	Жил бүр	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль “MNS” 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах
2	Үнсэн сангаас хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах	Үнсэнд агуулагдаж байгаа металлууд бороо, цасны нөлөөгөөр уусч, хөрс бохирдуулж байгаа эсэхэд хяналт тавих	Үнсэн сангийн талбай				Үйл ажил-лагааны зардал	Жил бүр	
3	Хөрсний бохирдол	Үйлдвэрийн технологийн хог хаягдал, шатах тослох материалыг зориулалтын саванд цуглуулах	Станцын эзэмшлийн талбайд				Үйл ажил-лагааны зардал	Жил бүр	
Үнсэн сан									
1	Үнсэн сангаас нөлөөлөх нөлөөллийг бууруулах	Үнсний орчныг (pH) тодорхойлж, борооны ус болон станцын усаар шахагдан үнсэн санд хуримтлагдахад хүчиллэг болон шүлтлэг урсац үүссэн эсэхийг хянах	Үнсэн сангийн талбай				Орчны хяналт шинжил-гээний хөтөлбөрийн хүрээнд	Жил бүр	
2		Үнсэн сангаас зөөж овоолго үүсгэсэн үнсний хийсэлтийг багасгах арга хэмжээ авах	Үнсэн сангийн талбай	м²				Гэрээт компани ажиллуулна.	Жил бүр
ДҮН									

6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Өнөөгийн байдлаар компанийн хашаанд бутлаг ургамал 37624 ширхэг модлог ургамал 2569 ширхэг бүгд 40193 модыг ургуулан арчилж байна. Энэ жил 2220 мод шинээр тарьж ургуулан усан оргилуур орчмын 70 ширхэг насжилт өндөртэй улиас модыг сугалан авсан.

Цаашид өөрийн мод үржүүлгийн талбайг нэмэгдүүлж, нэр төрлийг олшруулан үрслүүлэх, эрт ургацын цэцэг ургуулахын тулд хүлэмжинд дулаацуулга тавих бэлтгэл ажлыг хангаж байна. 2025 оноос зарим модыг өөрсдийн үрслүүлсэн модноос ашиглан тарихаар зорьж байгаа. Станцын эзэмшлийн талбайн өнгө үзэмж, тоосжилтыг бууруулах зорилгоор станцын салхины дээд талд ногоон байгууламж байгуулах, суулгаж буй мод бутны ургалт, өсөлтийг нэмэгдүүлэх, ургах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хөрсийг бордох, сайжруулах, ногоон байгууламжийг арчлах, гадаад үзэмжинд нөлөөлөх цэцгийн мандал байгуулах, сукцесст орсон хэсгийг нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөсөн.

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Эзэмшлийн талбайн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх	Ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн мэргэжлийн хүнээр хийлгэх	Станцын эзэмшлийн талбайд					V-IX сард	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2 дахь заалт
2		Талхлагдсан газарт олон наст ургамлын үр тариалж, ургамалжуулах	Цэцгийн үр, зүлэгний үр, цэцгийн сав	кг	500		4,856,500		
3		Станцын орчныг тохижуулах, мод бут тарих	Гацуур, шар хуайс, голт бор, чацаргана	ш	295		5,795,550		
4		Ногоон байгууламжийн хөрсийг үржил шимт хөрсөөр хучих, арчилгаа усалгаа	Хар шороо, бордоо	м³	72		11,925,650		
5	“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд мод тарих		685	ш					
ДҮН							22,577,170		

7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“ДЦС-4” ТӨХК-ийн хими цехэд битүү системд тринатрифосфат, гидразин, аммиак, давсны хүчил, хүхрийн хүчил, шүлт болон +саармагжуулалтад этилийн спирт, содын уусмал, борын хүчил, цууны хүчил зэрэг бодисыг ашигладаг. Хими цех нь технологийн шаардлага хангасан давсгүйжүүлсэн химийн цэвэр болон зөөлрүүлсэн усаар станцыг тасралтгүй хангаж, уур-ус, түлш, тосны чанарыг хангах үүрэгтэй байдаг. Дээрх бодисуудыг хадгалах зориулалт бүхий хадгалах төхөөрөмж болон агуулах нь анх дулааны цахилгаан станц байгуулагдахад олон улсын стандартын шаардлагын дагуу баригдаж төхөөрөмжлөгдсөн болно. “ДЦС-4” ТӨХК нь тендер зарлаж, эрх бүхий гэрээлэгч байгууллагаас шаардлагатай химийн бодисуудыг захиалан авч ашигладаг байна. Үйлдвэрлэлийн нөхцөлд хэрэглэх химийн бодисуудыг зориулалтын саванд битүүмжилж хадгалан ашигладаг.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх,хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэм-жээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Химийн бодисын сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдах	Химийн бодис асгарсан үед саармагжуулах арга хэмжээ авах багаж хэрэгслийг бэлэн байлгах	Хими цех, химийн лаборатори, түлшний лаборатори			Үйл ажил-лагааны зардал	Жилийн турш	Химийн хорт болон аюултай бодисын тухай МУ-ын хууль
2		Химийн хорт бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг зохих шаардлагын дагуу явуулах				Үйл ажил-лагааны зардал	Жилийн урш	
3		Химийн хорт болон аюултай бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах, химийн бодисын хадгалалт, ашиглалт, зарцуулалтанд тогтмол хяналт тавих	Станцын хэмжээнд химийн бодис ашиглаж байгаа цех, нэгж		-	Үйл ажил-лагааны зардал	Жилийн турш	
ДҮН								

8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Өөрийн эзэмшлийн тайлбайгаас үүссэн ахуйн хог хаягдлыг автомашинаар тээвэрлэн “Хот тохижилтийн газар” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж, СХД-ийн төвлөрсөн хогийн цэгт хаяж байгаа. “ДЦС-4” ТӨХК-ийн эмнэлгээс гарч байгаа аюултай хог хаягдлыг “Элемент медикал” ХХК-тай гэрээ байгуулан устгуулах, халдваргүйжүүлэх, тээвэрлүүлэх үйлчилгээг 7 хоногт 2 удаа татан авалт хийлгүүлэхээр хамтран ажиллаж байна. Хадгалагдаж байгаа химийн бодисуудыг вакуум уутаар вакуумдаж агаарт тархах эрсдэлийг бууруулан хадгалсан. Тухайн жилд химийн бодис нийлүүлсэн компанид химийн бодисын сав баглаа боодлыг тэр жилд нь буцаан өгч ажиллах, тендерийн бичиг баримтад тусгагдсан. Үйлдвэрлэлийн хаягдал усыг үнсээ үнсэн сан руу зөөвөрлөж, тунгааж дахин үнс зайлуулахад ашигладаг.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм-жих нэгж	Тоо хэм-жээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Энгийн хог хаягдал									
1	Энгийн хог хаягдал	Хог хаягдлын цогц менежментийг журам боловсруулах	Станцын эзэмшлийн талбайд				Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	
2		Энгийн хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулаж, төвлөрсөн хогийн цэгт хаях	Станцын эзэмшлийн талбайд				Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	
3		Энгийн хог хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах	Станцын эзэмшлийн талбайд				Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	
4		Хог хаягдлыг ангилан зориулалтын саванд цуглуулах, дахин ашиглах	Станцын эзэмшлийн талбайд				Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	
5		Станцын үйлдвэрлэлийн хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах	Хуурай үнс	тн			Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	

6	Үйлдвэрийн хог хаягдал	Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей"-г дахин боловсруулж, устгуулах зорилгоор гүйцэтгэгчид шилжүүлэх	Станцын хэмжээнд	тн	1,5		Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	
7	Аюултай хог хаягдал	Эмнэлгийн хог хаягдлын ачилт, тээвэрлэлт, устгалд, аюулгүйн хайрцаг, уут устгуулах	Станцын эмнэлгийн хэсэг	кг	-		Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	
ДҮН									

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа, давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Яндангийн хаягдал утаанд агуулагдах бохирдуулагч буюу CO, SOx, NOx, үнс	Зуухан цех	Жилийн турш	Тогтмол		Үйл ажиллагааны зардал	Утааны хийн суурин анализатор болон зөөврийн газоанализатор ашигладаг.	MNS 5919:2008
2	БН болон ШО-гийн нүүрсэнд элементийн шинжилгээ, үнсэнд 44 элементийн шинжилгээ хийлгэх	Нүүрсний талбай	Жилд 1 удаа	1	1,500,000	1,500,000	Хөндлөнгийн лабораторид	MNS ISO 589:2003 MNS ISO 1171:2009 MNS ISO 562:2001 MNS ISO 1928:2009
3	БН, ШО-гийн нүүрсний хяналтын шинжилгээ хийлгэх	Нүүрсний талбай	Жилд 1 удаа	1	1,000,000	1,000,000	Хөндлөнгийн лабораторид	
4	БН болон ШО-гийн нүүрсний үнсэнд цацрагийн шинжилгээ хийлгэх	Зуухны цахилгаан шүүлтүүр	Жилд 1 удаа	1	1,000,000	1,000,000	Цацрагийн хяналтын лаборатори	MNS 5072:2018 MNS 5626:2006
5	Трансформаторуудын тосны хроматографын шинжилгээ хийх	БТ трансформатор	Улирал тутам	4			Цахилгаан цехийн лабораторид	

7	Усны шинжилгээ Усны чанарын шинжилгээ	Ахуйн бохир ус	Жилд 4 удаа	4		Үйл ажил- лагааны зардал	СХЗГ-ын ХАБУЛЛ	MNS 4943:2015
		Ундны ус	Жилд 4 удаа	4				
	ДҮН					3,500,000		

10.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			I улирал	II улирал	III улирал	IV улирал		
1	Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах, сөрөг нөлөөллийг бууруулах	6,722,830	+	+	+	+	Хяналтын хэлтсийн дарга	
2	Нөхөн сэргээх арга хэмжээ	18,128,330		+	+			
3	Химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах		+	+	+	+		
4	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх		+	+	+	+		
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,500,000	+	+	+	+		
6	Тэрбум мод хөтөлбөр	4,449,500		+	+			
	ДҮН	32,800,660						

ДЦС-4 ТӨХК-ИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ

